



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/528

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.2 дахь, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотноо 2017 оны 10 дугаар сарын 27-28-ны өдөр зохион байгуулагдах "Саркопен ба насны доройтол" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн их эмч Х.Мэндхүүд 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг "Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх"- зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ